БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2022/164/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2022 он

Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 70342580 Цахим хаяг: ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716 Цахим хаяг: enhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Пүрэвсүрэн
Утас: 70353717 Цахим хаяг: dalaivan.orkhon@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт ........................................................................................................ 2-3

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл..........................................................4

3. Аудитын тайлан ..........................................................................................................11

3.1 Ерөнхий зүйл ........................................................................................................ 11

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.................................................................. 12

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ...................................................................... 13

3.4 Материаллаг байдал .................................................................................................. 13

3.5 Санхүүгийнтайлангийн тодруулга ................................................................................. 13

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .................................................................. 13

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг......................................................... 15

3.8 Аудитын гол асуудал ................................................................................................. 15

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....................... 15

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ................................................................................. 16

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал...................................................................... 16

4. Аудитын илрүүлэлт......................................................................................................17

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ...........................................................................18

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ХАА | Хөдөө аж ахуй |

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-3259
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 63

танай________________ны №_________________т

МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗРЫН ДАРГА
Г.ОДСҮРЭН ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

D:/bichighereg/2022A4toot

006020085

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **335,756,717.02** | **303,251,476.61** |
| 33 | Авлага | | 7 200,000.00 |
| **33500** | | | |
| **34** | **Урьдчилгаа** | | 7 200,000.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | | 7 200,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 335,756,717.02 | 296,051,476.61 |
| **351** | **Түүхий эд материал** | 305,771,984.88 | 272,069,875.93 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 194,230,888.68 | 189,796,555.36 |
| 35130 | Эм боох материал | 111,541,096.20 | 82,273,320.57 |
| **354** | **Хангамжийн материал** | 29,984,732.14 | 23,981,600.68 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,984,305.00 | 1,702,670.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 3,891,210.00 | 4,129,880.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,110,002.00 | 4,125.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 413,500.00 | 312,000.00 |
| 35470 | Бусад хамнамжийн материал | 20,585,715.14 | 17,832,925.68 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **421,899,704.66** | **385,564,949.04** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 421,899,704.66 | 385,564,949.04 |
| **392** | **Биет хөрөнгө** | 351,251,704.73 | 315,312,949.11 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 154,513,499.57 | 154,513,499.57 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (14,936,986.71) | (19,684,602.03) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 202,887,729.31 | 122,852,156.79 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (102,780,249.40) | (35,696,559.24) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 374,886,866.15 | 276,587,571.85 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (289,781,290.26) | (204,942,133.89) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 74,768,856.03 | 67,836,567.10 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (48,306,719.96) | (46,153,551.04) |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | 70,647,999.93 | 70,251,999.93 |
| 39301 | Программ хангамж | 1,980,000.0 | 1,980,000.0 |
| **39302** | Хуримтлагдсан элэгдэл-программ хангамж | (308.000.07) | (704.000.07) |
| **39303** | Бусад биет бус хөрөнгө | 68,976,000.00 | 68,976,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **757,656,421.68** | **688,816,425.65** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | 757,656,421.68 | 688,816,425.65 |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 757,656,421.68 | 688,816,425.65 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 757,656,421.68 | 688,816,425.65 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | 705,567,093.98 | 636,727,097.95 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 621,044,369.79 | 705.567,093.98 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 84,522,724.19 | (68.839.996.03) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 52,089,327.70 | 52,089,327.70 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **757,656,421.68** | **688,816,425.65** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,449,315,395.39** | **2,524,599,906.87** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **738,796,105.39** | **595,461,671.87** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 738,796,105.39 | 595,461,671.87 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 778,760.00 | 743,600.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 778,760.00 | 743,600.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 118,949,296.98 | 0 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-материал | 619,068,048.41 | 594,718,071.87 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,710,519,290.00** | **1,929,138,235.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 891,149,500.00 | 1,286,541,175.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 891,149,500.00 | 1,286,541,175.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **819,369,790.00** | **642,597,060.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | 601,660,500.00 | 619,327,300.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан | 217,709,290.00 | 23,269,760.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,364,792,671.20** | **2,592,193,856.50** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,364,792,671.20** | **2,592,193,856.50** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,337,274,73.78 | 2,385,360,600.42 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 226,907,400.00 | 583,435,719.60 |
| 210101 | Үндсэн цалин | 169,139,200.00 | 463,015,881.60 |
| 210102 | Нэмэгдэл | 51,048,700.00 | 108,955,198.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,719,500.00 | 11,464,640.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,632,500.00 | 82,476,134.82 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,556,100.00 | 53,647,952.21 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,261,100.00 | 5,967,955.41 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,815,200.00 | 10,619,679.35 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 453,900.00 | 1,112,777.39 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,538,200.00 | 11,127,770.46 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 37,217,048.19 | 56,080,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,052,574.19 | 5,920,844.22 |
| 210302 | Түлш, халаалт | 28,872,200.00 | 28,661,855.78 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,292,274.00 | 3,065,300.00 |
| 210304 | Байрны түрээс | | 18,432,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 42,525397.00 | 34,530,581.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 8,883,890.00 | 6,296,075.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 25,193,346.00 | 20,084,296.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,823,100.00 | 5,674,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 625,061.00 | 2,475,710.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 785,931,554.95 | 798,363,983.21 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 785,019,454.95 | 774,080,383.21 |
| **210503** | **Нормын хувцас, зөөлөн эдлэл** | 912,100.00 | 24,283,600.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 36,731,020.00 | 16,403,422.29 |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 60,000.00 | 1,142,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 8,303,480.00 | 1,021,797.29 |
| 210604 | Урсгал засвар | 28,367,540.00 | 14,239,325.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 8,196,000.00 | 10,558,579.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,196,00.00 | 10,558,579.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,123,167,676.21 | 749,072,518.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,121,497,811.21 | 744,029,946.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 965,000.00 | 918,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 304,865.00 | 401,572.50 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 400,000.00 | 3,600,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | | 123,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 45,966,137.43 | 54,439,662.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний зардал | 15,983,697.50 | 15,320,992.78 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 29,982,439.93 | 39,118,669.22 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 27,517,937.42 | 206,833,256.08 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 26,126,700.00 | 39,056,459.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 23,806,700.00 | 37,364,459.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,546,000.00 | 1,692,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,391,237.42 | 167,776,797.08 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,391,237.42 | 167,776,797.08 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **84,522,724.19** | **(67,593,949.63)** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | - | 1,246,046.40 |
| 225010 | Үнэ төлбөргүй гарсан зардал-үндсэн хөрөнгө | - | 1,246,046.40 |
| **6** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **84,522,724.19** | **(68,839,996.03)** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | 52,089,327.70 | 621,044,369.79 | 673,133,697.49 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | 52,089,327.70 | 621,044,369.79 | 673,133,697.49 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| Өмчид гарсан өөрчлөлт | | | 84,522,724.19 | 84,522,724.19 |
| Зарлагсан ноогдол ашиг | | 52,089,237.70 | 705,567,093.98 | 757,656,421.68 |
| Тайлант үеийн үр дүн | | | | |
| **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | | | |
| **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | | 52,089,327.70 | 705,567,093.98 | 757,656,421.68 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | 52,089,327.70 | 705,567,093.98 | 757,656,421.68 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | |
| Тайлант үеийн үр дүн | | | (68,839,996.03) | (68,839,996.03) |
| **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | 52,089,327.70 | 636,727,097.95 | 688,816,425.65 |

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,711,298,050.00** | **1,929,881,835.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **778,760.00** | **743,600.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 778,760.00 | 743,600.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 778,760.00 | 743,600.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 778,760.00 | 743,600.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,710,519,290.00** | **1,929,138,235.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 891,149,500.00 | 1,286,541,175.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 819,369,790.00 | 642,597,060.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах | 601,660,500.00 | 619,327,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан | 217,709,290.00 | 23,269,760.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,708,578,350.00** | **1,925,851,875.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,708,578,350.00** | **1,925,851,875.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,681,060,412.58 | 1,719,018,618.92 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 226,907,400.00 | 583,435,719.60 |
| 210101 | Үндсэн цалин | 169,139,200.00 | 463,015,881.60 |
| 210102 | Нэмэгдэл | 51,048,700.00 | 108,955,198.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,719,500.00 | 11,464,640.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,632,500.00 | 82,476,134.82 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 21,556,100.00 | 53,647,952.21 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,261,100.00 | 5,967,955.41 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,815,200.00 | 10,619,679.35 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 453,900.00 | 1,112,777.39 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,538,200.00 | 11,127,770.46 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 37,817,048.19 | 56,080,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,052,574.19 | 5,920,844.22 |
| 210302 | Түлш, халаалт | 29,472,200.00 | 28,661,855.78 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,292,274.00 | 3,065,300.00 |
| 210304 | Байрны түрээс | | 18,432,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 40,987,975.00 | 29,831,129.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,185,900.00 | 6,194,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,636,275.00 | 15,478,419.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,823,100.00 | 5,674,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,242,700.00 | 2,483,910.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 171,990,875.00 | 182,867,540.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 170,818,385.00 | 158,582,140.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,172,490.00 | 24,285,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 39,544,740.00 | 16,424,330.00 |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | 2,345,600.00 | 1,142,230.00 |
| 210604 | Урсгал засвар | 26,703,140.00 | 14,257,700.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 10,496,000.00 | 1,024,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 8,196,000.00 | 10,558,579.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 8,196,000.00 | 10,558,579.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,124,838,374.39 | 755,92,086.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,123,168,509.39 | 743,679,514.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 965,000.00 | 918,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 304,865.00 | 401,572.50 |
| 210807 | Газрын төлбөр | | 123,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 400,0000.00 | 10,800,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 145,500.00 | 1,423,100.00 |
| 210901 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 145,500.00 | 1,423,100.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **27,517,937.42** | **206,833,256.08** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 26,126,700.00 | 39,056,459.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 205,000.00 | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн урамшуулал тэтгэмж | 23,806,700.00 | 37,364,459.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,115,000.00 | 1,692,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 1,391,237.42 | 167,776,797.08 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,391,237.42 | 167,776,797.08 |
| **8** | **Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 2,719,700.00 | 4,029,960.00 |
| **9** | **Хөрөнгө оруулалт мөнгөн зардлын дүн** | 2,719,700.00 | 4,029,960.00 |
| **223** | **Бусад хөрөнгө** | 2,719,700.00 | 4,029,960.00 |
| **223004** | **Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал** | 2,719,700.00 | 4,029,960.00 |
| | **Хөрөнгө оруулалт цэвэр мөнгөн гүйлгээ** | (2,719,700.00) | (4,029,960.00) |

### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,408,574,100.00 | 1,121,905,865.92 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,408,574,100.00 | 1,121,905,865.92 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,298,885,400.00 | 1,082,849,406.92 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 775,056,000.00 | 583,435,719.60 |
| 210101 | Үндсэн цалин | 552,775,400.00 | 463,015,881.60 |
| 210102 | Нэмэгдэл | 198,429,200.00 | 108,955,198.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 23,851,400.00 | 11,464,640.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 104,632,300.00 | 82,476,134.82 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 73,630,300.00 | 63,647,952.21 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,750,500.00 | 5,967,955.41 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,200,400.00 | 10,619,679.35 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,550,100.00 | 1,112,777.39 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 15,501,000.00 | 11,127,770.46 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол** | 56,457,300.00 | 56,080,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| | **зардал** | | |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,859,900.00 | 5,920,844.22 |
| 210302 | Түлш, халаалт | 29,067,900.00 | 28,661,855.78 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,096,700.00 | 3,065,300.00 |
| 210304 | Байрны түрээс | 18,432,800.00 | 18,432,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,955,800.00 | 27,295,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,654,700.00 | 6,194,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 12,206,300.00 | 11,542,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,195,900.00 | 5,674,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,898,900.00 | 3,883,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 46,606,500.00 | 46,606,280.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 22,321,100.00 | 22,320,880.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 24,285,400.00 | 24,285,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 19,054,300.00 | 19,054,300.00 |
| 210601 | Багаж, техник хэрэгсэл | 3,772,200.00 | 3,772,200.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 1,024,400.00 | 1,024,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,257,700.00 | 14,257,700.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 987,600.00 | 958,500.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 987,600.00 | 958,500.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 266,990,100.00 | 266,797,472.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр | 254,554,900.00 | 254,554,900.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 918,000.00 | 918,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 594,200.00 | 401,572.50 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 10,800,000.00 | 10,800,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 123,000.00 | 123,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 145,500.00 | 145,500.00 |
| 210901 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 145,500.00 | 145,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 109,688,700.00 | 39,56,459.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нэг удаагийн мөнгөн урамшуулал | 107,996,700.00 | 37,364,459.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,692,000.00 | 1,692,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,408,574,100.00 | 1,121,162,265.92 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | | |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | | |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | | |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 743,600.00 | 743,600.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 53 | 53 |
| 620001 | Удирдах ажилтан | 3.00 | 3.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | | 18 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 32 | 32 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **640199172.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **640199172.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 640199172.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3935619.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,935,619.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 136261260.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 136,261,260.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 9600079.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 9,600,079.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 489124614.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 489,124,614.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1277600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,277,600.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **2397888.00** |
| 213303 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 2,397,888.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 642597060.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 642597060.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 619,327,300.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 23,269,760.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймгийн Мал эмнэлгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь "Бейкер Тилли Далайван аудит" ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, Орхон аймгийн төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган аймгийн Мал эмнэлгийн газар нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 05 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээг технологийн хугацаанд чанартай хэрэгжүүлэх, мал эмнэлгийн ажил үйлчилгээний чанар, хүртээмж, үр дүнг сайжруулах, сумын мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн, гэрээт мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч нарыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, мал амьтныг өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрүүлжүүлэх нэгдсэн бодлогыг хэрэгжүүлж, мал сүргийг эрүүлжүүлэх арга хэмжээ графикт хугацаандаа хийгдэж дууссан.

Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль батлагдсантай холбоотой Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 267 дугаар тогтоол, ХХААХҮ-ийн Сайдын 2018 оны А/174 дүгээр тушаалаар 2019 оны 01 дүгээр сарын 01 өдрөөс Булган аймгийн Мал эмнэлгийн газар байгуулагдаж, 51 хүний бүтэц, орон тоотой ажиллаж байна.

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн Сайдын 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А-13 дугаар тушаалын хэрэгжилтийг хангах, бэлтгэл ажлын хүрээнд нийт 9 албан хаагчид мэдэгдэл өгч, МЭЕГ-аас ирүүлэх Төрийн захиргааны албан хаагчдын шинэчлэгдсэн албан тушаалын тодорхойлолтын дагуу бүтэц орон тооны өөрчлөлтийг хийхээр төлөвлөсөн.

Хүний нөөцийн шинэчлэгдсэн цахим системийг тогтмол хөтөлж, санхүүгийн системтэй холбож, төрийн албан хаагч ажлаас чөлөөлөгдсөн, шинээр томилогдсон, ажил эрхлэлт болон ажилтны үндсэн мэдээлэлд орсон өөрчлөлтийг тухай бүр бүртгэж, төрийн албан хаагчдын хувийн хэрэг бүрдэлтийг журмын дагуу бүрэн бүрдүүлж, баяжилтийг хийсэн бөгөөд аймгийн ЗДТГ, ТЗУХ, Төрийн албаны салбар зөвлөлөөс хамтран зохион байгуулсан баримтын шалгалтад амжилттай дүн үзүүлсэн.

Төрийн албаны салбар зөвлөлд бүтэц, орон тооны мэдээлэл, сул орон тоог нөхөх захиалгаа тухай бүр хүргүүлж, төрийн албан хаагчийн шалгалтанд тэнцсэн болон нөөцөд байгаа иргэдээс сул орон тоогоо бүрдүүлэх чиглэлийг баримтлан ажиллаж, төрийн албаны ерөнхий шалгалтад 6 албан хаагч шалгалтад тэнцэж, 2 ажилтан Төрийн жинхэнэ албан хаагчийн тангарагаа өргөсөн бөгөөд тусгай шалгалтад 4 албан хаагч тэнцсэн.

Төрийн албаны зөвлөлийн шалгалтын дагуу, 2021 оны 10 сарын 27-ны өдрийн 275 дугаар тогтоол, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаж, төрийн жинхэнэ албан хаагчийн ерөнхий болон тусгай шалгалтад 7 албан хаагч тэнцсэн бөгөөд тогтоолын хэрэгжилтийн тайланг хугацаанд нь хүргүүллээ.

Төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчдыг мэдээллээр хангаж, зөвлөгөө дэмжлэг үзүүлэн, байгууллагын стратеги төлөвлөгөө, Хөдөлмөрийн дотоод журам зэрэг холбогдох хууль, дүрэмтэй танилцуулж, албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, Хөдөлмөрийн гэрээг батлуулж, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод чанарын баталгаажуулалт, статистик хариуцсан ахлах ажилтан ажилладаг хэдий ч тухайн ажилтан чиг үүргээ хэрэгжүүлснээр тодорхой үр дүн гарсан эсэх нь тодорхойгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мал эмнэлгийн газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 796,962.73 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 11,954.44 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 8,368.11 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган аймаг дахь Мал эмнэлгийн газар 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,420.4 мянган төгрөгөөр буюу 0.24 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |

| | | | |
|---|---|---|---|
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | |
| Бараа материал | 335,756.72 | 296,051.50 | (39,705.24) |
| Үндсэн хөрөнгө | 421,899.7 | 385,564.95 | (36,242.36) |
| **Нийт хөрөнгө** | **757,656.42** | **688,908.82** | **(68,747.60)** |
| Өр төлбөр | 0.0 | 0.0 | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 757,656.42 | 688,908.82 | (68,747.60) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **757,656.42** | **688,908.82** | **(68,747.60)** |

Бараа материалын данс 296,051.50 мянган төгрөг болж 39,705.24 мянган төгрөгөөр буурсан нь эм эмнэлгийн хэрэгсэл шаардлага хангахгүй болж устгалд оруулсан шалтгаалсан байна. Бараа материалын тайланг сар бүр хянан баталгаажуулан ажиллаа. Бараа материалын тайланг хагас бүтэн жилээр тооллогын комисс тоолж баталгаажуулсан. Тооллогоор илүүдэлтэй болон дутагдалтай хөрөнгө байсангүй. Бараа материалын тайланд хөрөнгө оруулалтаар шилжиж ирсэн 594.718.71,87 төгрөгийн эм бэлдмэл, тусгай зориулалттай бараа материалын тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал дансанд бүртгэсэн.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 692,745,795.31 мянган төгрөг болж 185,267,156 мянган төгрөгөөр буурсан нь хөрөнгийг төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр 2021 оны дугаар тогтоолоор 3 ширхэг авто машин актласнаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 688,908.82 мянган төгрөг болж 68,747.60 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Булган аймаг дахь Мал эмнэлгийн газрын санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого өмнөх оноос 75,284.51 мянган төгрөгөөр буюу 3.7 хувиар, нийт зардал өмнөх оноос 227,308.79 мянган төгрөгөөр буюу 9.61 хувиар тус тус өссөн байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл,нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Мал эмнэлгийн газар нь нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,522,300.64 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,522,300.64 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 235,759.5 мянган төгрөгөөр бууруулан 1,286,541.17 мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр 1,286,541.17 мянган төгрөгийг улсын төсвөөс, төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас 743.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, нэмэлт санхүүжилтээр 642,597.1 мянган урсгал үйл ажиллагаанд 1,121,905.87 мянган төгрөгийг зарцуулж, 167,776.8 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 77.7 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байгаа нь хангамж бараа материалын зардлыг 44.3 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардлыг 33.3 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлыг 0.2 мянган төгрөг, хангамж, дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

**3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн орон нутгийн санхүүжилт 619,327,300 мянган төгрөгийн вакцин үйлчилгээний хөлс, эм эмнэлгийн хэрэгслийн зардал, 23,269,760 мянган төгрөгийн санхүүжилтийг дээд шатны төсвийн захирагчаас буюу Мал эмнэлгийн төв лабариторийн газраас тандалт судалгааны зардлаар тус тус олгосон байна.

**3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

**3.8 Аудитын гол асуудал**

Шатахууны гэрээний дагуу олгодог 365.0 мянган төгрөгийн шатахууны урамшууллыг орлогод авч бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.5-д "Нягтлан бодох бүртгэлд бүх орлогыг заавал бүртгэнэ" заалтын дагуу үнэ төлбөргүй орлогод бүртгэх. Мөн Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу е баримтгүй буюу хувь хүний сугалаатай анхан шатны баримтаар 180.0 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасны дагуу иж бүрэн баримтаар гүйлгээг хийж хэвших гэж заасантай нийцэхгүй байна.

**3.9Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь шилэн дансны цахим хуудсанд тогтмол болон тухай бүр мэдээлэх 139 мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлсэн, ковид цар тахлын тусгаарлалтанд байсан шалтгаанаар 1,10 дугаар сарын хугацаа хоцроосон 6 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна. Шилэн дансны мэдээлэл 92 хувьтай хэрэгжсэн байна.

Мөн шилэн дансанд мэдээлэх мэдээллийн талаар талбар бүрээр зөвлөгөө өглөө.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, харин хичээл үйлдвэрлэлийн зардлаас авсан зарим бараа материал цахим төлбөрийн е-баримтгүй зөвхөн нэхэмжлэх, зарлагын баримттай байгаа болон шатахууны тооцоо бодсон баримт, жолоочийн тооцооны хуудас бүрэн хөтлөөгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 13.5, 13.6 дахь заалт, Сангийн сайдын 2017 онд баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилтийг 90 хувьтай хангуулсан байна. Шалтгаан нь шилэн дансны мэдээллийг энэ онд дахин хоцроосон байна.

Хүснэгт . Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | тоо | дүн | тоо | дүн | тоо | дүн | хувь |
| Акт | - | - | - | - | | | |
| Албан шаардлага | - | | - | | | | |
| Зөвлөмж | 4 | 4,563.0 | 3 | 4,563.0 | 1 | - | |
| Нийт дүн | 4 | 4,563.0 | 3 | 4,563.0 | 1 | - | |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн 87-08 БУЛ дугаар бүхий автомашины километрийн спидометр ажилладаггүй явсан км тодорхойгүй нь анхаарал татахаар бөгөөд бусад чухал асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 545.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 884.2 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад залруулсан алдаа байхгүй.

### 4.2 Акт

Аудитын явцад акт байхгүй.

### 4.3 Албан шаардлага

87-08 БУЛ дугаар бүхий автомашины километрийн спидометр ажилладаггүй явсан км тодорхойгүй тооцоо бодолт, шатахууны тайлан хангалтгүй байгааг албан шаардлага хүргүүлэв.

Өгсөн албан шаардлага: Шатахууны тооцоог бодитой үнэн зөв хийж  тайланг холбогдох заавар журмын дагуу бүрэн хийж хэвших

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Орлогын данстай холбоотой асуудал***

*1.1. Илрүүлэлт:*

Шатахууны гэрээний дагуу олгодог 365.0 мянган төгрөгийн шатахууны урамшууллыг орлогод авч бүртгэлд тусгаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх," Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.5-д "Нягтлан бодох бүртгэлд бүх орлогыг заавал бүртгэнэ" заалтын дагуу үнэ төлбөргүй орлогод бүртгэх шалгуурт нийцэхгүй байна.

*1.2. Өгсөн зөвлөмж:  Үнэ  төлбөргүй хүлээн авсан орлогыг заавар журмын дагуу бүртгэх*

***2. Зардлын ланстай холбоотой асуудал***

*2.1. Илрүүлэлт:*

Анхан шатны баримтын иж бүрдэл дутуу е баримтгүй буюу хувь хүний сугалаатай анхан шатны баримтаар 180.0 мянган төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”  гэж заасны дагуу иж бүрэн  баримтаар гүйлгээг хийж хэвших заасныг мөрдөөгүйтэй холбоотой байна.

*2.2. Өгсөн зөвлөмж:*

3. *Анхан шатны баримтыг хууль, дүрмийн* дагуу иж бүрэн  баримтаар гүйлгээг хийж хэвших

***4. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

*4.1. Илрүүлэлт:*

Жолоочийн тооцооны хуудсыг үнэн зөв, бүрэн хөтлөөгүй, тооцоо бодсон баримт хангалтгүй, дотоод хяналт хэрэгжүүлээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4, 13.5, 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалт, Сангийн сайдын 2017 онд баталсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцэхгүй байна.

4.2. *Өгсөн зөвлөмж:*

Шатахуун зарцуулалтын анхан шатны баримтыг заавар аргачлалын дагуу хөтөлж, байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд үр нөлөөтэй хяналт хэрэгжүүлж, үр дүнг үнэлэх.

***5. Шилэн дансны хэрэгжилттэй холбоотой асуудал***

5.1. *Илрүүлэлт:*

Тайлант хугацаанд Шилэн дансанд 1,10 сарын 6 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна. Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1.мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх; 4.1.3." тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтын дагуу хугацаанд нь мэдээлж байх гэж заасныг мөрдөөгүйтэй холбоотой байна. Тайлант оны эцсээр нягтлан солигдсон тул дахин зөвлөмж өгөв.

5.2. *Өгсөн зөвлөмж:*

Байгууллагын шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн мэдээлж, дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, хариуцлагыг сайжруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Мал эмнэлэг газар | 4 | 545.0 | | | | | 1 | - | 3 | 545.0 |
| Дүн | | 4 | 545.0 | | | | | 1 | - | 3 | 545.0 |

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

БЭЛТГЭСЭН:

“БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ” ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР: Б.ПҮРЭВСҮРЭН

ХЯНАСАН:

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР,ЗАХИРАЛ : Д.МЯГМАРСҮРЭН

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР: Ж.ЭНХЦООДОЛ

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

БУЛГАНАЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Д.АНХБАЯР